



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А67

Улаанбаатар хот

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спорт наадмын хаалтын арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спорт наадмын хаалтын арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.


2. Хаалтын арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2.940.000 /Хоёр сая есөн зуун дөчин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн
А/сг дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын
спорт наадмын хаалтын арга хэмжээг
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Телевизын нэвтүүлэг бэлтгэх	2.000.000
2.	Тайз, карказ, гэрэлтүүлэг	940.000
ДҮН:		2.940.000